



113 Page



114 Page



115 Page

Иошуа

-Joshua-

Тайлбарлагч Израиль ард түмнийг удирдаж байсан Мосе Канаан нутагт орохын өмнө нас барсан учир Бурхан шинэ удирдагчаар Иошуаг томилжээ.

Бурхан Бүү ай, бүү санаа зов. Би Мосетэй хамт байсан шигээ чамтай ч мөн хамт байх болно. Мосед амласан Канаан нутаг уруу чамайг оруулах болно.

Тайлбарлагч Бурхан үргэлж хамт байна гэж Иошуад хэлсэн учир Иошуагийн айдас сарнижээ. Ингээд Иошуа Иерихо хот уруу хоёр тагнуулчаа явуулав. Тэр хоёр хот уруу ороод Рахаб гэгч эмэгтэйн гэрт байрлахдаа, тэр хотын тухай олон зүйлийг мэдэж авчээ.

Цэрэг Яадаг билээ! Израилийн хэдэн цэрэг манай нутгийг тагнахаар иржээ!!

Тайлбарлагч Израилийн тагнуулчид Иерихо хотод ирсэн гэдгийг мэдсэн хаан маш их уурлаж, тэднийг барихыг тушаажээ. Тэр үед Рахаб тагнуулчдыг зугтахад нь туслав.

Рахаб Би та нарт тусалсан шиг та нар энэ хотыг эзлэхээр ирэхдээ намайг болон гэр бүлийг минь амьд үлдээгээрэй.

Тайлбарлагч Тагнуулчид Рахабт амлаж, ямар ч аюулгүйгээр зугтан гарч чаджээ.

Тайлбарлагч Дөчин жилийн турш цөлд амьдарч байсан Израилийн ард түмэн Бурханы амласан газар болох Канаан нутгийн ойролцоо Иордан голд тулан иржээ. Канаан нутаг үнэхээр сайхан харагдаж байлаа. Израиль ард түмэн Канаан уруу орохын тулд Иордан голыг гатлах хэрэгтэй болов. Завь ч байхгүй, гүүр ч байхгүй, урсгал нь маш ширүүн. Ийм үед голыг гатлана гэдэг боломжгүй зүйл байв.

Эрэгтэй (хуруугаараа хот уруу чичлэн зааж) Яана даа тэр хүртэл яаж явнаа!

Эмэгтэй (мөрөө хавчин) Харин тийм ээ, энэ ёстой боломжгүй зүйл.

Тайлбарлагч Тэр үед Бурхан Иошуад ингэж хэлэв.

Бурхан Би Мосетэй хамт байсан шигээ чамтай хамт байна гэдгийг тэдэнд мэдүүл! Иордан голд орж хөлөө усны захад дүр гэж гэрээний авдрыг дамнасан тахилчидад тушаа! Ингэх үед урсаж байгаа ус овоорон тогтож хуурай газар ил гарах болно.



116 Page



117 Page

- Тайлбарлагч** Гэрээний авдрыг үүрсэн тахилчид Иордан голд хөлөө дүрмэгц үнэхээр голын урсгал ус овоорон тогтож хуурай газар ил гарчээ.
- Иошуа** За болгоомжтой гатлаарай. Бие биенээ түлхээд байлгүй, удаан гараарай.
- Эмэгтэй** Бурхан минь танд баярлалаа!
- Эрэгтэй** Улаан тэнгисийг гаталсантай адил гайхамшгийг би биеэрээ үзэж байна даа! Гайхалтай!
- Тайлбарлагч** Израильчууд Бурханы үйлдсэн гайхамшгийг дахин мэдэрч Иордан голыг эсэн мэнд туулан гарч чаджээ.

- Тайлбарлагч** Иерихо цайзын өмнө ирэхэд Бурхан Иошуад ингэж хэлэв.
- Бурхан** Та нар энэ цайзыг эзэлж авах болно. Бүх дайчин эрс хотыг нэг удаа тойр. Үүнийг зургаан хоног хий. Зөвхөн тахилчид эвэр бүрээ үлээх бөгөөд өөр хэн ч ямар ч чимээ гаргаж болохгүй. Сүүлийн долоо дахь өдөр нь хотыг долоон удаа тойроод, тахилчид бүрээг үлээхэд, бүгд чангаар хашхирцгаа. Тэр үед Иерихо цайз нуран унах болно.
- Тайлбарлагч** Иошуа Израилийн ард түмэнд энэ бүхнийг дамжуулан хэлэв.
- Иошуа** Цайзыг тойрох явцдаа ямар ч чимээ гаргаж болохгүй шүү. Намайг хашхир гэж хэлэх үед хашхираарай!!
- Тайлбарлагч** Тэгээд нэг дэх өдөр, хоёр дахь өдөр гээд зургаан өдрийн туршид бурханы үгийн дагуу чимээгүйгээр цайзыг тойрчээ.

- Тайлбарлагч** Ингээд долоо дахь өдөр болжээ. Энэ өдөр Бурханы хэлсний дагуу цайзыг долоон удаа тойроод, тахилчид эвэр бүрээ үлээхэд тэд чангаар хашхиралджээ.
- Иошуа** Нэг дуугаар хашхирцгаая!! Бурхан бидэнд энэ хотыг өгсөн!
- Ард түмэн** Аааааааа~~~~~ааааааа Уухай !
- Тайлбарлагч** Хашхирч эхэлмэгц Иерихо цайз ганхаж эхэлжээ. Эцэст нь цайз нурж унав. Цайзыг нурах үед дотор нь байсан бүх хүн нурангид дарагдан амьсгал хураажээ. Тагнуулчид амласан ёсоор Рахаб эмэгтэй болон түүний гэр бүлийг амьд үлдээв. Бурханы үгийг дуулгавартай дагасан Иошуа болон Израиль ард түмэн амлалтын Канаан нутагт амьдрах болжээ.